



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/329

Номгон


Төрийн байгууллагуудын ажиллах цагийн
хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.2, аймгийн Онцгой комиссын 2021 оны 44 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын зарим үйл ажиллагааг нээж байгаатай холбогдуулан иргэд, олон нийтийнхээ эрүүл, идэвхитэй ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлсэг орчныг бий болгох зорилгоор нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нутгийн захиргаа, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болон хууль хяналтын байгууллагын ажиллах цагийн хуваарийг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 1 цагаар урагшлуулж, 08:00-17:00 цагийн хооронд ажиллуулахаар хуваарьт өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх байгууллагууд ажлын өдрүүдэд 08:00 цагаас 17:00 цагийн хооронд, 7 хоногийн хугацаанд 40 цаг ажиллахаар цагийн зохицуулалт хийхийг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

621010839